



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/114

Булган сум

Эрүүл мэнд, боловсролын салбарын
удирдах албан хаагчдын уулзалт,
сургалтад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 2.2, Монгол улсын Засгийн газрын 2023 оны “Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” 322 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрүүл шүд” арга хэмжээг эрчимжүүлэн, хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулсан жишиг аймаг болох чиглэлээр боловсрол, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны нэгдсэн сургалт, уулзалтыг зохион байгуулсугай.

2. Сургалт уулзалтын хөтөлбөрийг 1 дүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, уулзалтад зарцуулагдах 2,115,000 (хоёр сая нэг зуун арван таван мянган) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 14-ний өдрийн А/м. дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

БУЛГАН АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЛБАН
ХААГЧДЫН СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Цаг 1	Сэдэв 2	Хариуцах албан хаагч 3
09:00-09:30	Бүртгэл	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Боловсролын газрын мэргэжилтэн
09:30-10:00	Нээлт	Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир Аймгийн Засаг даргын эрүүл мэндийн зөвлөх Б.Батбаяр
10:00-10:30	Монгол улсын ЗГ-ын 2023 оны 322 дугаар тогтоол “Эрүүл шүд” арга хэмжээний танилцуулга	Аймгийн Засаг даргын эрүүл мэндийн зөвлөх Б.Батбаяр
10:30-11:00	2025-2028 онуудад Булган аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарт хийгдэх ажлууд, өнөөгийн тулгамдсан асуудал	Аймгийн Засаг даргын эрүүл мэндийн зөвлөх Б.Батбаяр
11:00-12:00	Асуулт, хариулт, санал	
12:00-12:30	Цайны завсарлага	
12:30-13:30	Төлөвлөх ур чадварын амжилттай туршигдсан аргууд	ОМ консалтингийн сургагч багш
13:30-14:30	Ажлын бүтээмж ба гүйцэтгэл	ОМ консалтингийн сургагч багш
14:30	Сургалтын хаалт	

Аймгийн Засаг даргын 20.25 оны
02 дугаар сарын 13-ны/ний өдрийн 4/114 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

БУЛГАН АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЛБАН
ХААГЧДЫН СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ /Төгрөг/	
				Нэгжийн үнэ	Нийт
1	2	3	4	5	6
1	Цайны зардал	Ширхэг	75	8500	637,500
2	Цэвэр ус	Ширхэг	75	1300	97,500
3	ОМ консалтингийн сургагч багшийн зардал	Цаг	2	690,000	1,380,000
НИЙТ ДҮН				2,115,000	